



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ
СУРГУУЛИЙН ХАРЬАА
**ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/91

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 5 тоот тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”, ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн дүрмийн 4.10.12, 4.10.14, 4.10.15 дахь заалтууд, ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн захирлын зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ШУТИС-ийн харьяа технологийн коллежийн багш, ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлж, урамшуулах журам”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан журмыг мөрдөж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Журмыг шинэчлэн баталсантай холбоотой ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн захирлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн тушаалаар баталсан “ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн багш, ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлж, урамшуулах журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалыг 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн мөрдсүгэй.

ЗАХИРАЛ



Д.ДУЛМАА

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын 20.25 оны 12
дугаар сарын 04-ны өдрийн 1191 дугаар тушаалын хавсралт



	ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн багш, ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлж, урамшуулах журам ШУТИС-ТК	Эхний хэвлэлт	2024
		Өөрчилсөн огноо	2025
		Өөрчлөлтийн дугаар	1

ШУТИС-ИЙН ХАРЬЯА ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН БАГШ, АЖИЛТНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЖ, УРАМШУУЛАХ ЖУРАМ

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын 2025 оны 12
дугаар сарын 04-ны өдрийн 191 дугаар тушаалын хавсралт



АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ	3
ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ	3
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ	3
ТАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЖ, УРАМШУУЛАЛ ОЛГОХ	4
Хавсралт 1. Холбогдох маягт	9

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын 2025 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 119 дугаар тушаалын хавсралт



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн эрхэм зорилго, алсын хараа, хөгжлийн зорилтууд, түүнд хүрэхэд чиглэсэн ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийг бодит үр дүнтэй харьцуулан шалгуур үзүүлэлтийн тусламжтай үнэлж дүгнэн, ажлын үр дүнд тохирсон урамшуулал олгохтой холбогдох харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2 Гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулал олгох үйл ажиллагаа нь үнэн зөв, шударга, бусдаас хамааралгүй, бодит гүйцэтгэсэн ажлыг нь тоо, чанарын хувьд нарийн ялгаж үнэлэх мөч ил тод, үр дүнтэй байхад чиглэгдэнэ.
- 1.3 Захиргааны холбогдох нэгжүүд нь жил бүрийн цалин урамшууллын бодлогын хэрэгжилтэд судалгаа хийж, удирдлагыг мэдээллээр хангах, үндсэн цалингийн болон үр дүнгийн урамшууллын үр нөлөөг дээшлүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах үүрэг хүлээнэ.
- 1.4 Багш, ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх үйл ажиллагааг ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн захиргаанаас удирдлагаар хангаж, явцын хяналт тавьж ажиллана.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн захирлын тушаалаар батлагдсан үндсэн орон тоонд ажилладаг профессор багш, ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг урамшуулахад энэхүү журмыг мөрдөнө.

ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- 3.1 Дараах баримт бичгийг хэсэгчлэн, норматив байдлаар эш татсан болно. Үүнд:
 - ✓ Төрийн албаны тухай хууль, 2017;
 - ✓ Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам. 2012;
 - ✓ Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам, 2019;
 - ✓ “Судалгаанд суурилсан их сургууль” Үндэсний хөтөлбөр. 2018 он;
 - ✓ ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн дүрэм, журмууд

ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1 Гүйцэтгэлийн үнэлгээ: Технологийн коллежийн багш, ажилтан бүр үүрэгт ажлаа хэрхэн биелүүлж, ямар үр дүнд хүрч байгаа, мэргэшлийн бэлтгэл, ажлын ачаалал ямар байгаа талаарх мэдээлэл цуглуулж, дүгнэх үйл явц.
- 4.2 Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт: Аливаа бодлого, зорилт, төлөвлөгөө, үндсэн зорилтод хэрхэн хүрч байгааг тодорхойлох хэмжүүр бөгөөд төлөвлөсөн зорилтод хүрсэн эсэхийг тодорхойлохын тулд юуг хэмжиж, үнэлэхийг гаргаж өгнө.
- 4.3 Урамшуулал: Байгууллагын ажлын эцсийн үр дүнд багш, ажилтны оруулсан хувь нэмэр, хүчин чармайлтыг үнэлэн, ажил олгогчоос олгож буй мөнгөн урамшуулал.
- 4.4 Багш: Үндсэн багшийн орон тоонд ажиллаж буй багш
- 4.5 Ажилтан: Үндсэн орон тоонд ажиллаж буй ажилтан (Захирал, сургалтын албаны дарга, ахлах нягтлан бодогч, тэнхимийн эрхлэгч, гадаад харилцааны менежер, гадаад харилцааны ажилтан, нийгмийн ажилтан, захирлын туслах, захиргааны ажилтан, сургалтын албаны ажилтан, барилга ашиглалтын менежер, сургалтын мастер, нярав, үйлчлэгч)

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын 20.25 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 4/91 дугаар тушаалын хавсралт



ТАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЖ, УРАМШУУЛАЛ ОЛГОХ

- 5.1 Ажлын гүйцэтгэлийн үнэлгээг дараах зорилгоор хийнэ. Үүнд:
- 5.1.1 Ажил үүргээ ямар түвшинд гүйцэтгэх байгаа талаар удирдлага, ажилтнууд бодитой мэдээлэлтэй болох
 - 5.1.2 Ажилтны үндсэн ажлаасаа (албан тушаалын тодорхойлолтод зааснаас) илүү гүйцэтгэж буй ажлын хэмжээг тодорхойлох;
 - 5.1.3 Ажилтнуудын бүтээмжийг нэмэгдүүлэх сэдлийг үүсгэх;
 - 5.1.4 Сургалт, хөгжүүлэлтийн хэрэгцээ, шаардлага боломжийг тодорхойлох;
 - 5.1.5 Цалин хөлс болон урамшуулал олгох бодит үндэслэлийг тогтоох;
 - 5.1.6 Хангалтгүй гүйцэтгэлийг сайжруулах зэрэг болно.
- 5.2 Багш, ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг албан тушаалын ангилалд харгалзуулан тодорхойлно. Үүнд:
- 5.2.1 Багшийн хувьд:

Хүснэгт 5.1

№	Түлхүүр үзүүлэлт	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Дүгнэх огноо
1	Төлөвлөгөөт ажил (50%)	Албан тушаалын тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээнд заагдсан ажил үүргийг гүйцэтгэсэн байдал	50
2	Тусгай ажил (30%)	Сургалтын үйл ажиллагаанд дэвшилтэт арга зүй, технологи нэвтрүүлсэн, ашигласан, нутагшуулсан байдал, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн санаачилга, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд оролцсон байдал	10
3		Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн чиглэлээр их сургуульд оруулсан хувь нэмэр	10
4		Сургуулийн хөгжилд оруулсан материаллаг болон мөнгөн хөрөнгө оруулалт	5
5		Олон улсын, үндэсний болон их сургуулийн хэмжээнд гаргасан томоохон амжилт - Уралдаан, тэмцээн, наадам, үзэсгэлэнд оролцсон байр эзэлсэн, бүтээл нь шалгарсан; -Нэрэмжит тэтгэлэг, грант хүртсэн;	5
6	Хувь хүний чадамж (20%)	Олон улсын түвшинд сургуулийг төлөөлөн ажилласан байдал	5
7		Багшлах ур чадвар, мэргэжил, хувь хүний хөгжлөө дээшлүүлсэн байдал: -Гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан - Зөвлөх, мэргэшсэн инженерийн сургалтад хамрагдсан; -Эрдмийн зэрэг хамгаалсан, Эрдмийн цол хүртсэн	5
8		Онцгой үүрэг, даалгавар биелүүлсэн байдал (Сургуулийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр удирдлагаас тусгайлан даалгасан үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байдал)	5
9		Удирдлагаас өгсөн, хугацаатай үүрэг даалгаврын биелэлт, шууд удирдлагын үнэлгээ	
10		Хамтран ажилладаг хамт олны үнэлгээ	5
		Нийлбэр оноо	100

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын 20.25 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 1/94 дугаар тушаалын хавсралт



Жич: Багш нь /маягт-1/ Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний хүснэгт, /маягт-2/ Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний тайланг бичиж, тэнхимийн эрхлэгчээрээ үнэлүүлнэ.

5.2.2 Ажилтны хувьд:

Хүснэгт 5.2

№	Түлхүүр үзүүлэлт	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Дүгнэх оноо
1	Төлөвлөгөөт ажил (50%)	Албан тушаалийн тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээнд заагдсан ажил үүргийг гүйцэтгэсэн байдал	50
2	Тусгай ажил (30%)	Сургуулийн бодлогын баримт бичиг, журам, дүрэм, бусад эрх зүйн актуудыг боловсруулахад оролцсон байдал, сургуулийн хөгжилд хувь нэмэр оруулсан байдал	10
		Олон улсын, үндэсний болон их сургуулийн хэмжээнд гаргасан томоохон амжилт -Уралдаан тэмцээн, наадам, үзэсгэлэнд оролцсон байр эзэлсэн, бүтээл нь шалгарсан; -Нэрэмжит тэтгэлэг, грант хүртсэн;	10
		Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норм, дүрэм, үйл ажиллагааны стандартыг баримтлан ажилласан байдал	10
3	Хувь хүний чадамж (20%)	Эд хөрөнгийн болон санхүүгийн хариуцлага алдахгүй ажилласан байдал, албан бичиг хэрэг хөтлөлт, архивт хүлээлгэн өгсөн байдал, тайлан, мэдээ мэдээллийг хугацаанд нь гаргасан байдал	5
4		Онцгой үүрэг, даалгавар биелүүлсэн байдал (Их сургуулийн тавьсан зорилго, зорилт, удирдлагаас хэрэгжүүлэх үйл ажиллагааг хангах чиглэлээр удирдлагаас тусгайлан даалгасан үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байдал)	5
5		Мэргэжил, ур чадвар, хувь хүний хөгжлөө дээшлүүлсэн байдал: - Гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан; Эрдмийн зэрэг хамгаалсан, эрдмийн цол хүртсэн.	5
6		Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байдал, шууд удирдлагын үнэлгээ	
7		Хамтран ажилладаг хамт олны (газар, алба, салбар, тэнхим) үнэлгээ	5
		Нийлбэр оноо	100

Жич: Ажилтан нь /маягт-3/ Ажилтны гүйцэтгэлийн үнэлгээний хүснэгт, /маягт-4/ ажилтны гүйцэтгэлийн үнэлгээний тайланг бичиж, шууд удирдлагаараа үнэлүүлнэ.

- 5.3 Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ 71% буюу түүнээс дээш үед урамшуулал олгох бөгөөд ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн захиргаа, нэгжийн удирдлагууд хамтран зохион байгуулна.
- 5.4 Нийт багш ажилтнуудын албан тушаалын 1 сарын үндсэн цалингийн 20 хүртэл хувиар сар бүр тооцон улирлын төгсгөлд жилд 2 удаа олгоно.
- 5.5 Ажлын гүйцэтгэлийн үр дүнг дараах үнэлгээний шатлалаар хэмжинэ.

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын 20.25 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 119 дугаар тушаалын хавсралт



Хүснэгт 5.3

№	Нийт үнэлгээний оноо	Тайлбар	Харгалзах урамшууллын хувь хэмжээ
1	90-100	Дээд үнэлгээ буюу багш, ажилтны гүйцэтгэлийн өндөр үзүүлэлт.	Тухайн сар буюу улиралд олгох урамшууллыг 100 хувь олгоно.
2	81-90	Хангалттай сайн үнэлгээ буюу багш, ажилтны ажиллах ур чадвар, идэвх санаачлага, гүйцэтгэлийн түвшин өндөртэйг илэрхийлнэ	Тухайн сар буюу улиралд олгох урамшууллын 75 хувийг олгоно.
3	71-80	Сайн үнэлгээ буюу гүйцэтгэлийн хүлээн зөвшөөрөхүйц түвшинд хүрснийг илэрхийлнэ.	Тухайн сар буюу улиралд олгох урамшууллын 50 хувийг олгоно.
4	51-70	Гүйцэтгэлийн дундаж үнэлгээ буюу багш, ажилтан идэвх санаачлага гарган ажиллаж буйг илтгэнэ	
5	50	Багш, ажилтан зөвхөн албан тушаалын тодорхойлолтод заагдсан, үүргийг бүрэн гүйцэтгэсэн илтгэх үнэлгээ	
6	0-49	Багш, ажилтан нь албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргийг бүрэн гүйцэтгэхгүй байгааг илтгэх үнэлгээ	

Жич: албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргийг (төлөвлөгөөт ажил) хангалтгүй гүйцэтгэж байгаа тохиолдолд ажилтны ажлын гүйцэтгэлийг сайжруулах талаар холбогдох арга хэмжээг тухайн нэгжийн удирдлагаас авах үүрэгтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн “Хөдөлмөрийн дотоод журам”, хөдөлмөрийн гэрээг үндэслэн хариуцлага тооцох саналыг гаргана.

- 5.6 Сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн чиглэлд гүйцэтгэсэн зарим ажилд олгох урамшууллыг тусгайлан тооцно. Тусгайлан урамшуулал олгох ажлыг дүгнэх аргачлал, харгалзах урамшууллын хэлбэр, хувь хэмжээ, мэргэжлийн комиссын ажиллах удирдамжийг ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын тушаалаар батлан мөрдөнө.
- 5.7 Сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн ажлын үр дүнгээр олгох тусгайлсан урамшууллыг хичээлийн жилд 1 удаа олгоно.
- 5.8 Сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн ажлын үр дүнгээр тусгайлсан урамшууллыг дараах ажлуудад олгоно. Үүнд:
 - Web of Science, Scopus зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн индекстэй, чансаа өндөртэй сэтгүүлд ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн нэр дээр эрдэм шинжилгээний бүтээл, өгүүлэл хэвлүүлсэн;
 - Судалгааны ажлын үр дүнгээр олон улсын, үндэсний хэмжээний томоохон шагнал хүртсэн;
 - Улсын болон ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн төсвийн бус хөрөнгө, эх үүсвэрээр иж бүрдэл тоног төхөөрөмж бүхий судалгааны лаборатори байгуулсан;
 - Судалгааны лаборатори магадлан итгэмжлүүлсэн;

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын 20.25 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 1191 дугаар тушаалын хавсралт



- Инновацийн шинэ бүтээгдэхүүн, технологи, гарган үйлдвэрлэлд нэвтрүүлсэн;
- Сургалтын хөтөлбөрийг олон улсад магадлан итгэмжлүүлсэн.

Жич: Тусгайлсан урамшуулал олгосон тохиолдолд 5.3-р заалтад тусгагдсан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэнд эдгээр ажлуудыг хамааруулан тооцохгүй.

5.9 Гүйцэтгэлийг үнэлэх, үнэлүүлэхдээ доор дурьдсан албан тушаалтнуудын хуваарилалтыг баримтална.

Хүснэгт 5.4

№	Гүйцэтгэлийг үнэлэх удирдах ажилтан	Гүйцэтгэлээ үнэлүүлэх албан тушаал
1	Удирдах зөвлөлийн дарга	Захирал
2	Захирал	Сургалтын албаны дарга
		Тэнхимийн эрхлэгч
		Ахлах нягтлан бодогч
		Захирлын туслах
		Барилга ашиглалтын менежер
		Захиргааны ажилтан
		Гадаад харилцааны менежер
		Нийгмийн ажилтан
		Үйлчлэгч
3	Сургалтын албаны дарга	Сургалтын албаны ажилтан
4	Тэнхимийн эрхлэгч	Тэнхимийн багш
		Сургалтын мастер
5	Ахлах нягтлан бодогч	Нярав
6	Гадаад харилцааны менежер	Гадаад харилцааны ажилтан

5.10 Багш, ажилтны ажлыг дүгнэж, урамшуулал олгох асуудлыг хэлэлцсэн протокол, шийдвэрийг албан ёсоор үйлдэж, нэгж, салбар, тэнхимд хадгална.

5.11 Ажлын үр дүнгийн гүйцэтгэлийн үнэлгээний мэдээллийг удирдах албан тушаалтнууд тухай бүр багш, ажилтнуудад хүргэж байна.

5.12 Ажлын гүйцэтгэлийн урамшууллыг дараах багш, ажилтанд олгохгүй. Үүнд:

- Сахилгын шийтгэлтэй байх хугацаанд; (Хөдөлмөрийн тухай хуулийн 123.8 дахь заалтыг мөрдөнө)¹
- Ажил олгогчийн санаачлагаар хөдөлмөрийн гэрээ нь цуцлагдсан
- Туршилтын хугацаанд ажиллаж байгаа; (Албан тушаалын өөрчлөлттэй холбоотой туршилтын хугацаанд ажиллаж байгаа ажилтанд хамаарахгүй)
- ШУТИС-ийн харьяа Технологийн коллежтой хөдөлмөрийн гэрээнээс бусад гэрээ байгуулан түр ажиллаж буй иргэн;

¹ 123.8 Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно.

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын 20.25 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 1191 дугаар тушаалын хавсралт



- Багш, ажилтны хувьд тухайн хичээлийн жилийн улирлын, гүйцэтгэх ажилтны хувьд тухайн сарын нийт үргэлжлэх хугацааны 50 хувиас дээш хугацаанд хүндэтгэх шалтгааны улмаас ажиллаагүй, албан ёсны чөлөөтэй байсан, түр чөлөөлөгдсөн.
- 5.13 Тухайн хичээлийн жилд чөлөөлөгдсөн багш, ажилтанд урамшуулал олгохдоо ажилласан хугацаанд харгалзуулан тооцно.
- 5.14 Урамшуулал олгохдоо тухайн оны төсөвт тусгагдсан батлагдсан зардлын хэмжээг баримтлана.
- 5.15 Албан тушаалын тодорхойлолтонд заагдсан, төлөвлөгөөт ажил үүргээ хангалттай гүйцэтгэсэн боловч ажлын гүйцэтгэлийн урамшуулал авах нөхцлийг хангаагүй нь тухайн багш, ажилтан ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж үзэх үндэслэл болохгүй.
- 5.16 Ажлын гүйцэтгэлийн үнэлгээтэй холбогдон гарсан маргаан, гомдлыг холбогдох дүрэм, журмын хүрээнд шийдвэрлэнэ.

--oOo--

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын 20.25 оны 12
дугаар сарын 04-ны өдрийн 11/01 дугаар тушаалын хавсралт



Хавсралт 1. Холбогдох маягт

№	Маягтын нэр	Маягтын дугаар	Хариуцах нэгж/ хадгалалт
1	Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний хүснэгт	Маягт 1	Тэнхимийн эрхлэгч
2	Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний тайлан	Маягт 2	Тэнхимийн эрхлэгч
3	Ажилтны гүйцэтгэлийн үнэлгээний хүснэгт	Маягт 3	Нэгж
4	Ажилтны гүйцэтгэлийн үнэлгээний тайлан	Маягт 4	Нэгж
5	Гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн бүртгэл	Маягт 5	Захиргаа, тэнхим, нэгж

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын 20...²⁵ оны
12 дугаар сарын 04...-ний өдрийн 4/91 дүгээр тушаалын хавсралт



Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний хүснэгт

Маягт -1

Багшийн нэр:
Албан тушаал:
Харьяалагдах тэнхим:

Тэнхимийн эрхлэгч:
Үнэлгээний хамрах хугацаа:
Үнэлгээ хийсэн огноо:

№	Үнэлгээний бүлэг (түлхүүр үзүүлэлт)	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Харгалзах оноо	Үзүүлэлт тус бүрийн биелэлтийн оноо		Нийт бодит гүйцэтгэл оноо
				Өөрийн үнэлгээ	Удирдлагын үнэлгээ	
1	Төлөвлөгөөт ажил (50%)	Албан тушаалын тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээнд заагдсан ажил үүргийг гүйцэтгэсэн байдал	50			
2	Тусгай ажил (30%)	Сургалтын үйл ажиллагаанд дэвшилтэт арга зүй, технологи нэвтрүүлсэн, ашигласан, нутагшуулсан байдал, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн санаачилга, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд оролцсон байдал	10			
3		Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн чиглэлээр их сургуульд оруулсан хувь нэмэр	10			
4		Сургуулийн хөгжилд оруулсан материаллаг болон мөнгөн хөрөнгө оруулалт	5			
5		Олон улсын, үндэсний болон их сургуулийн хэмжээнд гаргасан томоохон амжилт (Уралдаан, тэмцээн, наадам, үзэсгэлэнд оролцсон байр эзэлсэн, бүтээл нь шалгарсан, нэрэмжит тэтгэлэг, грант хүртсэн)	5			
6	Хувь хүний чадамж (20%)	Олон улсын түвшинд сургуулийг төлөөлөн ажилласан байдал	5			
7		Багшлах ур чадвар, мэргэжил, хувь хүний хөгжлөө дээшлүүлсэн байдал (Гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан, зөвлөх, мэргэшсэн инженерийн сургалтад хамрагдсан)	5			
8		Эрдмийн зэрэг хамгаалсан, эрдмийн цол хүртсэн				
9		Онцгой үүрэг, даалгавар биелүүлсэн байдал (Сургуулийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр удирдлагаас тусгайлан өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн)	5			
10		Удирдлагаас өгсөн, хугацаатай үүрэг даалгаврын биелэлт, шууд удирдлагын үнэлгээ				
		Хамтран ажилладаг хамт олны үнэлгээ	5			
		Нийлбэр оноо	100			

Үнэлгээ хийлгэсэн багшийн гарын үсэг:/ /

Үнэлгээг баталгаажуулсан удирдах албан тушаалтны гарын үсэг:/ /

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын 20..25... оны
12 дугаар сарын 04...-ний өдрийн 1/91 дүгээр тушаалын хавсралт



Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний тайлан

Маягт -2

Багшийн нэр:

Албан тушаал:

Харьяалагдах тэнхим:

Тэнхимийн эрхлэгч:

Үнэлгээний хамрах хугацаа:

Үнэлгээ хийсэн огноо:

№	Үнэлгээний бүлэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Харгалзах оноо	Тухайн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийгдсэн ажлын нэр	Хүрсэн үр дүн /чанарын болон тоон үзүүлэлт/	Өөрийн үнэлгээ
1	Төлөвлөгөөт ажил (50%)	Албан тушаалын тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээнд заагдсан ажил үүргийг гүйцэтгэсэн байдал	50			
2	Тусгай ажил (30%)	Сургалтын үйл ажиллагаанд дэвшилтэт арга зүй, технологи нэвтрүүлсэн, ашигласан, нутагшуулсан байдал, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн санаачилга, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд оролцсон байдал	10			
3		Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн чиглэлээр их сургуульд оруулсан хувь нэмэр	10			
4		Сургуулийн хөгжилд оруулсан материаллаг болон мөнгөн хөрөнгө оруулалт	5			
5		Олон улсын, үндэсний болон их сургуулийн хэмжээнд гаргасан томоохон амжилт (уралдаан, тэмцээн, наадам, үзэсгэлэнд оролцсон байр эзэлсэн, бүтээл нь шалгарсан, нэрэмжит тэтгэлэг, грант хүртсэн	5			
6	Хувь хүний чадамж (20%)	Олон улсын түвшинд сургуулийг төлөөлөн ажилласан байдал	5			
7		Багшлах ур чадвар, мэргэжил, хувь хүний хөгжлөө дээшлүүлсэн байдал (Гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан, зөвлөх, мэргэшсэн инженерийн сургалтад хамрагдсан)	5			
8		Эрдмийн зэрэг хамгаалсан, эрдмийн цол хүртсэн				
9		Онцгой үүрэг, даалгавар биелүүлсэн байдал (Сургуулийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр удирдлагаас тусгайлан даалгасан үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байдал)	5			
10		Удирдлагаас өгсөн, хугацаатай үүрэг даалгаврын биелэлт, шууд удирдлагын үнэлгээ				
		Хамтран ажилладаг хамт олны үнэлгээ	5			
		Нийлбэр оноо	100			

Гүйцэтгэлийн үнэлгээний тайлан бичсэн багш:/

Тайланг баталгаажуулсан удирдах албан тушаалтны гарын үсэг:/

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын 20...25... оны
...12 дугаар сарын ...04...-ний өдрийн 1/91 дүгээр тушаалын хавсралт



Маягт – 3

Ажилтны гүйцэтгэлийн үнэлгээний хүснэгт

Ажилтны нэр:
Албан тушаал:
Харьяалагдах нэгж:

Удирдах албан тушаалтан:
Үнэлгээний хамрах хугацаа:
Үнэлгээ хийсэн огноо:

№	Үнэлгээний бүлэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Харгалзах оноо	Өөрийн үнэлгээ	Удирдлагын үнэлгээ	Нийт оноо
1	Төлөвлөгөөт ажил (50%)	Албан тушаалийн тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээнд заагдсан ажил үүргийг гүйцэтгэсэн байдал	50			
2	Тусгай ажил (30%)	Сургуулийн бодлогын баримт бичиг, журам, дүрэм, бусад эрх зүйн актуудыг боловсруулахад оролцсон байдал, сургуулийн хөгжилд хувь нэмэр оруулсан байдал	10			
		Олон улсын, үндэсний болон их сургуулийн хэмжээнд гаргасан томоохон амжилт (Уралдаан тэмцээн, наадам, үзэсгэлэнд оролцсон байр эзэлсэн, бүтээл нь шалгарсан, нэрэмжит тэтгэлэг, грант хүртсэн)	10			
		Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норм, дүрэм, үйл ажиллагааны стандартыг баримтлан ажилласан байдал	10			
3	Хувь хүний чадамж (20%)	Эд хөрөнгийн болон санхүүгийн хариуцлага алдахгүй ажилласан байдал, албан бичиг хэрэг хөтлөлт, архивт хүлээлгэн өгсөн байдал, тайлан, мэдээ мэдээллийг хугацаанд нь гаргасан байдал	5			
4		Онцгой үүрэг, даалгавар биелүүлсэн байдал (Сургуулийн тавьсан зорилго, зорилт, удирдлагаас хэрэгжүүлэх үйл ажиллагааг хангах чиглэлээр удирдлагаас тусгайлан даалгасан үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байдал)	5			
5		Мэргэжил, ур чадвар, хувь хүний хөгжлөө дээшлүүлсэн байдал: - Гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан; - Эрдмийн зэрэг хамгаалсан, эрдмийн цол хүртсэн.	5			
6		Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байдал, шууд удирдлагын үнэлгээ				
7		Хамтран ажилладаг хамт олны (газар, алба, салбар, тэнхим) үнэлгээ	5			
		Нийлбэр оноо	100			

Үнэлгээ хийлгэсэн ажилтны гарын үсэг:/ /
Үнэлгээг баталгаажуулсан удирдах албан тушаалтны гарын үсэг:/ /

Жич: Ажилтны гүйцэтгэлийн үнэлгээний тайлан /маягт-3/-ийн хамтаар хүчинтэй.

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын 20.25 оны
12 дугаар сарын 04-ний өдрийн 119 дүгээр тушаалын хавсралт



Ажилтны гүйцэтгэлийн үнэлгээний тайлан

Маягт – 4

Ажилтны нэр:
Албан тушаал:
Харьяалагдах нэгж:

Удирдах албан тушаалтан:
Үнэлгээний хамрах хугацаа:
Үнэлгээ хийсэн огноо:

№	Үнэлгээний бүлэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Харгалзах оноо	Тухайн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийгдсэн ажлын нэр	Хүрсэн үр дүн /чанарын болон тоон үзүүлэлт/	Өөрийн үнэлгээ
1	Төлөвлөгөөт ажил (50%)	Албан тушаалийн тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээнд заагдсан ажил үүргийг гүйцэтгэсэн байдал	50			
2	Тусгай ажил (30%)	Сургуулийн бодлогын баримт бичиг, журам, дүрэм, бусад эрх зүйн актуудыг боловсруулахад оролцсон байдал, сургуулийн хөгжилд хувь нэмэр оруулсан байдал	10			
		Олон улсын, үндэсний болон их сургуулийн хэмжээнд гаргасан томоохон амжилт (Уралдаан тэмцээн, наадам, үзэсгэлэнд оролцсон байр эзэлсэн, бүтээл нь шалгарсан, нэрэмжит тэтгэлэг, грант хүртсэн)	10			
		Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норм, дүрэм, үйл ажиллагааны стандартыг баримтлан ажилласан байдал	10			
3	Хувь хүний чадамж (20%)	Эд хөрөнгийн болон санхүүгийн хариуцлага алдахгүй ажилласан байдал, албан бичиг хэрэг хөтлөлт, архивт хүлээлгэн өгсөн байдал, тайлан, мэдээ мэдээллийг хугацаанд нь гаргасан байдал	5			
4		Онцгой үүрэг, даалгавар биелүүлсэн байдал (Их сургуулийн тавьсан зорилго, зорилт, удирдлагаас хэрэгжүүлэх үйл ажиллагааг хангах чиглэлээр удирдлагаас тусгайлан даалгасан үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байдал)	5			
5		Мэргэжил, ур чадвар, хувь хүний хөгжлөө дээшлүүлсэн байдал: - Гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан; - Эрдмийн зэрэг хамгаалсан, эрдмийн цол хүртсэн.	5			
6		Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байдал, шууд удирдлагын үнэлгээ				
7		Хамтран ажилладаг хамт олны (газар, алба, салбар, тэнхим) үнэлгээ	5			
		Нийлбэр оноо	100			

Үнэлгээ хийлгэсэн ажилтны гарын үсэг:/...../

Үнэлгээг баталгаажуулсан удирдах албан тушаалтны гарын үсэг:/...../

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын 20.25 оны
12 дугаар сарын 04-ний өдрийн 179 дүгээр тушаалын хавсралт



Гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн бүртгэл

Маягт – 5

Нэгж:

Үнэлгээний хамрах хугацаа:

Үнэлгээ нэгтгэсэн огноо:

№	Багш, ажилтны нэр	Албан тушаал	Өөрийн үнэлгээ	Удирдлагын үнэлгээ	Гүйцэтгэлийн дундаж үнэлгээ	Харгалзах урамшууллын хувь
			%	%	%	
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						

Үнэлгээг нэгтгэсэн: /

Үнэлгээг хүлээн авсан: /

Тайлбар: Маягт 5-ыг зөвхөн нэгжийн удирдлага болон захиргааны ажилтан нэгтгэж ахлах нягтлан бодогчид өгнө.